

## МТ Шатахуун түгээх - II үе

Улс:	Монгол
Төслийн дугаар:	42200
Бизнесийн салбар:	Байгалийн нөөц
Төрийн/Хувийн:	Хувийн хэвшил
Байгаль орчны категори:	B
Захирлуудын Зөвлөлийн огноо:	2011 оны 03-р сарын 29
Статус:	Бүтцийн Хэлэлцүүлэг хийгдсэн, Эцсийн Хэлэлцүүлэг хүлээгдэж буй
Төслийн хураангуй нийтлэгдсэн огноо:	2011 оны 02-р сарын 23

### Төслийн тухай

ЕСБХБанк нь Монгол улсын Магнай Трейд Групп-д 50 сая ам.долларын нөхцөлт зээл олгохоор судалж байна. Уг зээлээр МТ Группын хөгжлийн хоёрдугаар үе шатыг дэмжин шинээр нефтийн агуулах болон шатахуун түгээх станц барих ажлыг санхүүжүүлнэ. Түүнчлэн санхүүжилтын зарим хэсэг нь ложистикийг сайжруулах, менежментийг мэдээллээр хангах системийг нэвтрүүлэх болон хийн түлшний (LPG) бизнесийг шинээр эхлэхэд зарцуулагдах болно.

### Шилжилтийн үйл явцад үзүүлэх нөлөөлөл

Төслийг хэрэгжүүлснээр шилжилтийн үйл явцад дараахь байдлаар нөлөө үзүүлнэ.

(a) нефтийн салбар дахь хувийн хэвшлийн хөгжил болон өрсөлдөөнийг дэмжих; мөн

(b) компанийн бизнес үйл ажиллагаа болон байгаль орчин хөдөлмөр хамгаалалт аюулгүй ажиллагаа(БОХХАА)-ны стандартуудыг сайжруулна.

### Бизнесийн болон байгаль орчны үйл ажиллагаануудын стандартыг тогтоох буюу сайжруулах

Уг төсөл нь дараахь хэд хэдэн стандартуудыг сайжруулахад хувь нэмэр оруулна:

(a) Компанийн төсвийн төлөвлөлт, санхүүгийн мэдээлэл болон зардлын хяналтын үйл явцыг сайжруулснаар ил тод байдлыг нэмэгдүүлнэ;

(c) БОХХАА-ны сургалтыг олон улсын өндөр туршлагатай мэргэжилтний тусламжтайгаар зохион байгуулснаар нефтийн салбарт дахь БОХХАА-г сайжруулна;

(d) Нефть олборлолтын салбар дахь компанийн БОХХАА-н ёс зүйг шинээр нэвтрүүлж, мөн ил тод уул уурхайн зарчмын дагуу ажиллана;

### Хувийн сектор болон өрсөлдөөнийг дэмжих

Энэхүү төсөл нь Монгол улс дахь нефтийн өсч байгаа өрсөлдөөнт зах зээлийн үед хувийн компанийн үйл ажиллагааг дэмжинэ. Түүнчлэн хийн түлшний (LPG) зах зээлд шинээр нэвтэрч ажиллах боломжийг Компанид олгоно.

### **Харилцагч**

Магнай Трейд ХХК ('МТ' буюу 'Компани'), нефтийн бүтээгдэхүүн импортлогч, борлуулагч Монголын компани.

### **ЕСБХБ-ны санхүүжилт**

50 сая ам.доллар хүртэлх нөхцөлт зээл

### **Төслийн нийт өртөг**

83 сая ам.доллар

### **Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл:**

Төслийг В зэрэглэлийн дагуу шалгасан болно. Банкны байгаль орчны мэргэжилтэн болон хөндлөнгийн шинжээч нар 2011 оны 2-р сард байгаль орчны нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэсэн. Байгаль орчны аудит болон шинжилгээ нь мөн хөндлөнгийн шинжээчээр хийгдсэн ба Байгаль Орчин Нийгмийн Үйл ажиллагаанд хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө (БОНУАХАТ) боловсруулагдаж байна. Уг төлөвлөгөөнд байгаль орчны менежмент, хяналт, агаарын бохирдол, хортой материалын тээвэрлэлт болон хадгалалт, хаягдлын менежмент, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, галын менежмент болон гэрээт борлуулалтын үйл ажиллагаа зэрэгт гүйцэтгэх ажлуудыг тусгасан. Өмнөх санхүүжилтын үед хийгдсэн БОНУАХАТ-г Компани нь сайн биелүүлж ажиллаж байгааг хөндлөнгийн аудит дүгнэлтдээ тэмдэглэсэн байна.

Шинэ БОНУАХАТ нь байгаль орчин болон хөдөлмөр аюулгүй байдлын ажиллагаан дээр учирч буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлон зааж өгсөн юм.

### **Техникийн хамтын ажиллагаа**

Байхгүй.

### **Компанитай холбоо барих**

Магнай Трейд ХХК  
Их тойруу 14, МТ барилга  
Шуудангийн хайрцаг 336  
Улаанбаатар 20  
Монгол Улс

### **Бизнес хамтын ажиллагаа**

Бизнес хамтын ажиллагааны боломжийн талаар харилцагч компанитай холбоо барина уу.

### **Ерөнхий лавлагаа авах**

ЕСБХБ-наас төсөлтэй холбоотой лавлагаа (ажил үйлчилгээ худалдаж авахтай холбоогүй):

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

Электрон шуудан: [projectenquiries@ebrd.com](mailto:projectenquiries@ebrd.com)

### **Олон Нийтэд Мэдээлэх Журам (ОНМЖ)**

ОНМЖ нь ЕСБХБ-аас өөрийн баримталж буй стратеги, журмууд болон явуулж буй үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөвмэдээлэл өгөх зорилгоор мэдээллийг хамааралтай этгээдэд хэрхэн түгээх, тэдэнтэй зөвлөлдөх үйл ажиллагааг зохицуулна. ОНМЖ-ыг доорхи холбоосоос үзнэ үү: [Text of the PIP](#)

### **Хараат Бус Санал Гомдлын Механизм (ХБСГМ)**

Тус Банкны төсөл нь хөндөнгийн хувь хүн, иргэн болон байгууллагад сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд тэдэнд хараат бус байдлаар санал гомдол тавих боломжийг олгох зорилгоор ЕСБХБ-аас Хараат Бус Санал Гомдлын Механизм (ХБСГМ)-ийг бий болгосон. Санал гомдол хүлээн авах, шийдвэр журмыг дараах холбоосоос үзнэ үү: [www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf](http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf)

Банкны санхүүжилт хийгдсэнээс хойш 12 сарын хугацаанд санал гомдлыг хүлээн авна. Банкны санхүүжилт хийгдсэн хугацааны талаар ХБСГМ-ийг хариуцсан мэргэжилтэнтэй [pcm@ebrd.com](mailto:pcm@ebrd.com) хаягаар эсвэл харъяа Банкны Төлөөлөгчийн Газартай холбогдож тодруулна уу.

---